



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/240

Өмнөдэлгэр сум

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн эрх шилжүүлэх гэрээ, хэлцлийг харгалзан газрыг хавсралтад дурдсан 2 иргэнд үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2.Гэр бүлийн нэг гишүүний өмчилж авсан газарт энэхүү захирамжийг үндэслэн газрын кадастр хийх, газар өмчлөгчид хүлээлгэн өгөх, хилийн заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх, улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралт дахь сумын Засаг даргын захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Газраа шилжүүлсэн иргэнд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.



Р.ЭНХТӨР

D:disk/bichig hereg/ zahiramj

2024100480

сумын Зас
15 дугаар с
А/1940 дугаар зах

ДҮН